

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРААС 2024 ОНД ДОТООД АУДИТ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох дүрэм, журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагын 2023 оны худалдан авах ажиллагаа явагдсан эсэхэд дотоод аудит хийж, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, удирдлагад үнэн, зөв мэдээлэл хүргэх, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж өгөх, үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, хугацаатай 8 зөвлөмжийг 03 сарын 20-нд хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж үр дүнг удирдлагад танилцуулсан.

2.УБЕГ-ын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын зарим заалтын хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах УБЕГ-ын даргын 2024 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн “Орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсийн хөдөлмөрийн дотоод журмын зарим зүйл хэсгүүдийн хэрэгжилтэд дотоод аудит хийх ажлын удирдамж”-ийн хүрээнд Архангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Төв, Увс аймгуудын улсын бүртгэлийн хэлтсийн төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн систем болон хүний нөөцийн удирдлагын системд төлөвлөгөөт шалгалтыг хийсэн.

Хөдөлмөрийн дотоод журмын зарим хэрэгжилтэд 2023 онд 10 аймаг сонгогдож шалгагдсан. Үлдсэн дээрх 11 аймгийн улсын бүртгэлийн хэлтсээс холбогдох мэдээллийг авч,

- ✓ Амралт, чөлөө, тэтгэмж, тусламж
- ✓ Шагнал, урамшуулал
- ✓ Ажлын хариуцлага чиглэлээр дотоод аудит гүйцэтгэсэн.

Шалгалтын үр дүнгээр ээлжийн амралт эдлэх хоног, ээлжийн амралтын цалин олговор, ажлын чөлөө олголт, албан хаагчдад дэмжлэг, тусламж үзүүлсэн тухай, ур чадварын нэмэгдэл, алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, хавсран, хослон, түр орлон гүйцэтгэсний нэмэгдэл хөлс, сахилгын шийтгэл, урамшуулал агуулгын хүрээнд алдаа, зөрчил тодорхойлон тус хэлтсүүдэд хугацаатай 10 зөвлөмжийг 04 сарын 27-нд хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг тооцон ажилласан.

3.УБЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг, даалгаврын хүрээнд “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨОХХК-ийн холбогдох зарим мэдээллийг гаргуулан авч, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал, хүсэлт авах, ажил сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор ажиллаж хугацаатай 15 зөвлөмжийг 06 сарын 05-нд хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцон ажилласан.

4.УБЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдөр баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх”

удирдамжийн хүрээнд Санхүү, аж ахуйн хэлтсээс 2023 оны холбогдох мэдээллийг гаргуулан авч, илэрсэн асуудалд чиглэсэн зөвөлгөө өгөх, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал, хүсэлт авах, ажил сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор ажиллаж, хугацаатай 25 зөвлөмжийг 06 сарын 18-нд хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг хүлээн авч ажиллалаа.

5.УБЕГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/20 тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн ерөнхий газрын ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 6.1 дэх заалтын дагуу тус сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод аудит хариуцсан нэгж хяналт тавих байдлаар ажиллаж, 2024 оны Ахмадын сангийн зарцуулалт, түүний тайлан мэдээнд дотоод аудит хийж 80 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээ өгч, дүнг илтгэх хуудсаар газрын даргад танилцуулж, цаашид анхаарч ажиллах 4 зөвлөмжийг 10 дугаар сарын 30-нд хүргүүлэн ажилласан.

6.Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газар нь ажлын байрны чиг үүргийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар 2016-2024 оны хооронд ажлаас халагдаж, чөлөөлөгдсөн албан хаагчдаас хууль бус шийдвэрийн улмаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн байгууллагаар тогтоогдсон 41 албан хаагчдыг ажилд нь буцаан авах, ажилгүй байсан хугацаанд ногдох цалин, нийгмийн даатгалыг нөхөх төлбөрийг буруутай албан тушаалтнаас нэхэмжлэх, бүрэн дүнгээр төлүүлсэн эсэх тухай судалгааны дүнг 11 сарын 06-нд удирдлагад илтгэх хуудсаар танилцуулсан. Үндэсний аудитын газрын санхүү-нийцлийн аудитор Нямсүрэнгийн шаардсанаар судалгааны дүнг мөн хүргүүлэн ажилласан.

7.Нийслэл, орон нутгийн санхүү бүртгэлийн ажилтан, нягтлан нар, удирдлагуудад танхимын болон цахим сургалтуудыг

- санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг давтан гаргахгүй байхад таниулах;
- анхан шатны баримт бүрдүүлэлт, тайлан мэдээ бүртгэх;
- эрсдэлийн менежмент, түүнийг тодорхойлох, үнэлэх, тайлагнах сэдвээр зохион байгуулсан.

БТДШГ-ын ахлах мэргэжилтэн С. Энхнаран